



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2024 оны 03 дугаар сарын 04
№09 (1305)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

199. Конвенцын нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай 563

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

200. Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх,
сэргээн сайжруулах бодлого батлах тухай Дугаар 08 564

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

201. Далайн хөдөлмөрийн тухай 2006 оны
конвенцод 2016 онд оруулсан нэмэлт, өөрчлөлт 576

202. Далайн хөдөлмөрийн тухай 2006 оны конвенцын
актад 2018 онд оруулсан нэмэлт, өөрчлөлт 578



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 12 дугаар
сарын 15-ны өдөр

Улаанбаатар
хот

КОНВЕНЦЫН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Далайн хөдөлмөрийн тухай 2006 оны конвенцод 2016, 2018 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Индрига Фола на Нөлл

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Улаанбаатар хот

2023 оны 12 дугаар сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 01 дүгээр
сарын 16-ны өдөр

Дугаар 08

Улаанбаатар
хот

Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлого батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Зэвсэгт хүчний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлого”-ыг хавсралтаар баталсугай.

2.Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 7.1.12 дахь дэд заалтын дагуу холбогдох хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэх;

2/Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан 2024 оны 1 дүгээр улиралд багтаан батлах;

3/Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах арга хэмжээ, шаардагдах зардлыг Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний болон жил бүрийн улсын төсвийн төсөлд тусгаж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

4/Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогын хэрэгжилтийн явцад хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Монгол Улсын Их Хуралд танилцуулах.

3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо /Б.Энх-Амгалан/-нд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЗЭВСЭГ, ТЕХНИКИЙГ ШИНЭЧЛЭХ, СЭРГЭЭН САЙЖРУУЛАХ БОДЛОГО

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлого нь зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах талаар төрөөс баримтлах бодлого, хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэл, удирдлага, зохицуулалтыг тодорхойлно.

1.2.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын батлан хамгаалах тухай хууль, Зэвсэгт хүчний тухай хууль, Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс болон тэдгээрт нийцүүлэн гаргасан хууль тогтоомж нь Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогын эрх зүйн үндэслэл болно.

1.3.Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлого нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод нийцсэн байна.

1.4.Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлого нь дэлхийн болон бүс нутгийн цэрэг-улс төрийн, цэрэг-стратегийн нөхцөл байдал, түүний өрнөл, хөгжлийн чиг хандлагад тулгуурлана.

Хоёр.Бодлогын зорилго, хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

2.1.Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогын зорилго нь зэвсэг, техникийн хадгалалтын чанарыг дээшлүүлэх, сэргээн сайжруулах хүчин чадлыг нэмэгдүүлэх, орчин үеийн зэвсэг, техник худалдан авах, үйлдвэрлэх замаар зэвсэгт хүчний үндсэн үүргээ биелүүлэх чадавхыг бүрдүүлэхэд оршино.

2.2.Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:

2.2.1.үндэсний аюулгүй байдлын болон төрийн батлан хамгаалах бодлогод нийцсэн байх;

2.2.2.улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баталгаажсан байх;



2.2.3. шинжлэх ухааны ололт, инновац, дэвшилтэт техник, технологид суурилсан байх;

байх; 2.2.4. төрийн болон албаны нууцын шаардлагыг хангасан

байх; 2.2.5. техник, технологийн ашиглалтын нийцлийг хангасан

байх. 2.2.6. цэргийн нөөцийг бүрдүүлэхэд чиглэсэн байх.

Гурав. Бодлогын зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээ

3.1. Зэвсэг, техникийн ашиглалт, хадгалалтыг технологийн горимын дагуу зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлж хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:

3.1.1. техникийн үйлчилгээ, хадгалалт, засварыг технологийн горимын дагуу зохион байгуулж, ашиглалтыг нэмэгдүүлнэ;

3.1.2. зэвсэг, техникийн хадгалалтын нөхцөлийг сайжруулна;

3.1.3. цэргийн нэгтгэл, ангийн техникийн засвар, үйлчилгээний чанар, хүчин чадлыг нэмэгдүүлнэ;

3.1.4. зэвсэглэлийн галт хэрэглэл, техникийн сэлбэг хэрэгсэл болон бусад материаллаг нөөцийг бүрдүүлнэ.

3.2. Зэвсэг, техникт төлөвлөгөөний дагуу сэргээн сайжруулах засвар, техникийн үйлчилгээ хийх зорилтын хүрээнд:

3.2.1. зэвсэг, техникийг сэргээн сайжруулах засвар, техникийн үйлчилгээг жил бүр төлөвлөгөөтэйгөөр хэрэгжүүлнэ;

3.2.2. зэвсэг, техникийн сэргээн сайжруулах хөрөнгийн зардлыг улсын төсөвт тусгана;

3.2.3. зэвсэг, техникийн засвар-үйлдвэрлэлийн техник, технологийг боловсронгуй болгох, их, дунд засвар хийх хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

3.3. Зэвсэг, техникийг худалдан авах, зээл, тусламжаар шинэчлэх зорилтын хүрээнд:

3.3.1. цэрэг-техникийн хамтын ажиллагааны хүрээнд удирдлага, холбоо, кибер аюулгүй байдал, радио электрон тэмцлийн



систем, төрлийн цэргийн үндсэн зэвсэглэл, тусгай зориулалтын техник хэрэгсэл, сум, галт хэрэглэлийг цэрэг-техникийн хамтын ажиллагаатай гадаадын улс орнуудын зээл, тусламжаар шинэчилнэ;

3.3.2.улсын төсвийн хөрөнгө оруулалтаар цэрэг, зэвсгийн удирдлагын систем, радио, радиотехникийн болон орон зайн тагнуулын техник, хэрэгсэл, агаарын довтолгооноос хамгаалах, танк эсэргүүцэх зөөврийн зэвсэглэл, нисдэг тэрэг, цэргийн болон тусгай зориулалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, буудлагын зэвсэг, сум, галт хэрэглэлийг худалдан авч шинэчилнэ.

3.4.Орчин үеийн техник, технологи, инновацыг нутагшуулах, цэргийн зарим төрлийн техник, хэрэгслийг эх орондоо үйлдвэрлэх зорилтын хүрээнд:

3.4.1.гадаадын цэргийн зэвсэглэл, техникийн дэвшилтэт технологийг нутагшуулах замаар үндэсний батлан хамгаалах аж үйлдвэрлэлийг хөгжүүлнэ;

3.4.2.батлан хамгаалах эрх ашигт нийцсэн технологийн инкубатор, туршилтын үйлдвэр, лаборатори, технологи дамжуулах төв, шинжлэх ухааны парк байгуулна;

3.4.3.дотоод нөөц бололцоонд тулгуурлан орчин үеийн техник, технологийн дэвшилд суурилсан нисгэгчгүй нисэх төхөөрөмж, робот, холбооны радиостанц, радиолокацын станц, зэвсэг, техникийн эд ангийг зохион бүтээж, туршин, үйлдвэрлэж, зэвсэглэлд нэвтрүүлнэ.

Дөрөв.Бодлогыг хэрэгжүүлэх санхүү, хөрөнгийн эх үүсвэр

4.1.Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

4.1.1.улсын төсөв;

4.1.2.цэрэг болон цэрэг-техникийн хамтын ажиллагааны хүрээнд гадаадын улс орнуудтай байгуулсан гэрээний дагуу олгосон хандив, тусламжийн орлого;

4.1.3.энхийг дэмжих ажиллагаанд оролцсоны нөхөн төлбөрийн Засгийн газраас тогтоосон хэсэг;

4.1.4.үндсэн хөрөнгө болон зэвсэглэлээс хасагдсан техник, тоног төхөөрөмж, материал хэрэгсэл, эд хөрөнгийг худалдан борлуулсны орлого;

4.1.5.зэвсэгт хүчнийг улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцуулж олсон ашгийн зохих хэсэг.

Тав.Бодлогыг хэрэгжүүлэх удирдлага, зохицуулалт

5.1.Улсын Их Хурал Зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

5.1.1.Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг үндэсний аюулгүй байдлыг хангах болон гадаад бодлогод нийцүүлэн тодорхойлох;

5.1.2.Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгаж батлах.

5.2.Засгийн газар Зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

5.2.1.Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүр улсын төсвийн төсөлд тусгах;

5.2.2.зэвсэг, техникийг шинэчлэх чиглэлээр гадаад улсын Засгийн газартай хамтран ажиллах тухай гэрээ, хэлэлцээр байгуулах.

5.3.Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

5.3.1.Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогын хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангах;

5.3.2.Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, Засгийн газраар хэлэлцүүлж батлуулах;

5.3.3.Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн батлан хамгаалах төсвийн төсөлд тусгаж, эрх бүхий байгууллагад хүргүүлэх;

5.3.4. гадаадын улс орнуудтай батлан хамгаалах аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх, зэвсэг, техник хэрэгслийг шинэчлэх, сэргээн сайжруулах чиглэлээр төсөл, хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх гэрээ, хэлэлцээр байгуулах.

5.4. Цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллага Зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогын хэрэгжилтийг хангах хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

5.4.1. Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогын хэрэгжилтийг хангах;

5.4.2. Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээний санал, холбогдох тооцоог боловсруулж, батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх.

---oOo---

Wannan tsarin ake gudanarwa a matsayin aiki.

Ƙirƙirar tsarin ake gudanarwa a matsayin aiki. Wannan tsarin ake gudanarwa a matsayin aiki.

Ƙirƙirar tsarin ake gudanarwa a matsayin aiki. Wannan tsarin ake gudanarwa a matsayin aiki.

Ƙirƙirar tsarin ake gudanarwa a matsayin aiki.

Ƙirƙirar tsarin ake gudanarwa a matsayin aiki. Wannan tsarin ake gudanarwa a matsayin aiki.

Ƙirƙirar tsarin ake gudanarwa a matsayin aiki. Wannan tsarin ake gudanarwa a matsayin aiki.

Ƙirƙirar tsarin ake gudanarwa a matsayin aiki.

Ƙirƙirar tsarin ake gudanarwa a matsayin aiki. Wannan tsarin ake gudanarwa a matsayin aiki.

Ƙirƙirar tsarin ake gudanarwa a matsayin aiki. Wannan tsarin ake gudanarwa a matsayin aiki.

Ƙirƙirar tsarin ake gudanarwa a matsayin aiki. Wannan tsarin ake gudanarwa a matsayin aiki.

Ƙirƙirar tsarin ake gudanarwa a matsayin aiki. Wannan tsarin ake gudanarwa a matsayin aiki.

Ƙirƙirar tsarin ake gudanarwa a matsayin aiki. Wannan tsarin ake gudanarwa a matsayin aiki.

Ƙirƙirar tsarin ake gudanarwa a matsayin aiki.

Ƙirƙirar tsarin ake gudanarwa a matsayin aiki.

Ƙirƙirar tsarin ake gudanarwa a matsayin aiki.

Ƙirƙirar tsarin ake gudanarwa a matsayin aiki.



6.0.0. Дорнодод үндсэрхэг ба дорнодод . Говьсүмбэр , аймгийн төлөөлөгчдийг сонгохын тулд сонгогчид үндсэрхэг ба дорнодод :
:

6.0.0.1 . Говьсүмбэр аймгийн төлөөлөгчдийг сонгохын тулд :
:

6.0.0.2 . Говьсүмбэр аймгийн төлөөлөгчдийг сонгохын тулд :
:

6.0.0.3 . Говьсүмбэр аймгийн төлөөлөгчдийг сонгохын тулд :
:

6.0.0.4 . Говьсүмбэр аймгийн төлөөлөгчдийг сонгохын тулд :
:

6.0.0.5 . Дорнодод үндсэрхэг ба дорнодод :
:

6.0.0.6 . Говьсүмбэр аймгийн төлөөлөгчдийг сонгохын тулд :
:

6.0.0.7 . Дорнодод үндсэрхэг ба дорнодод . Говьсүмбэр , аймгийн төлөөлөгчдийг сонгохын тулд сонгогчид үндсэрхэг ба дорнодод :
:

6.0.0.8 . Дорнодод үндсэрхэг ба дорнодод :
:

6.0.0.9 . Дорнодод үндсэрхэг ба дорнодод :
:

6.0.0.10 . Дорнодод үндсэрхэг ба дорнодод :
:



МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БАГА ХУРАЛ

ДАЛАЙН ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ 2006 ОНЫ КОНВЕНЦОД 2016 ОНД ОРУУЛСАН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

Далайн хөдөлмөрийн тухай 2006 оны конвенцын Журам 4.3-т холбогдох Актэд оруулсан нэмэлт, өөрчлөлт

Удирдамж В4.3.1 – Ажлын байрны осол, гэмтэл ба халдварт өвчлөл

1 дэх хэсгийн төгсгөлд дараах бичвэрийг нэмэх:

Мөн Олон улсын далайн тээврийн танхим болон Олон улсын тээвэр эрхлэгчдийн холбооноос хамтран гаргасан *Хөлөг онгоц дээрх дарамтлах, дээрэлхэх явдлыг арилгах тухай удирдамжийн* хамгийн сүүлийн хувилбарыг анхааран үзсэн байна.

4 дэх хэсэгт “болон” гэснийг (b) заалтын төгсгөлөөс хасаж, (c) заалтын төгсгөлд оруулах. Дараах заалтыг шинээр нэмэх:

(d) дарамтлах, дээрэлхэх.

Удирдамж В4.3.6 – Мөрдөн шалгах

2 дахь хэсэгт “болон” гэснийг (e) заалтын төгсгөлөөс хасаж, (f) заалтын төгсгөлд оруулах. Дараах заалтыг шинээр нэмэх:

(g) дарамтлах, дээрэлхэх явдлаас үүдэлтэй асуудлууд.

Далайн хөдөлмөрийн тухай 2006 оны конвенцын Журам 5.1-т холбогдох Актэд оруулсан нэмэлт, өөрчлөлт

Стандарт А5.1.3 – Далайн хөдөлмөрийн гэрчилгээ ба далайн зохистой хөдөлмөрийн тухай мэдэгдэл

4 дэх хэсгийг 3 дахь хэсгийн төгсгөлд оруулах.

4 дэх хэсгийг дараах байдлаар өөрчлөх:

Энэ Стандартын 1 дэх хэсэгт нөлөөлөхгүйгээр далайн хөдөлмөрийн гэрчилгээг дуусах хугацаанаас өмнө шинэчлэх шалгалт



хийгдсэний дараа хөлөг онгоц нь үндэсний хууль тогтоомж болон дүрэм, журам, эсхүл энэхүү Конвенцын шаардлагуудыг хэрэгжүүлэх бусад арга хэмжээний шаардлагад үргэлжлүүлэн нийцсэн хэмээн дүгнэсэн хэдий ч шинэ гэрчилгээг шинээр нэн даруй олгож, хөлгийн тавцан дээр бэлэн байлгах боломжгүй бол эрх бүхий байгууллага, эсхүл бүрэн эрх олгохоор хүлээн зөвшөөрөгдсөн байгууллага нь энэ зорилгоор хүчинтэй байгаа гэрчилгээний дуусах хугацаанаас өмнө 5 сараас илүүгүй хугацаагаар гэрчилгээг сунгаж, түүний дагуу гэрчилгээг хүлээн зөвшөөрч, батална. Шинэ гэрчилгээ нь энэ Стандартын 3 дах хэсэгт заасан огноо бүхий өдрөөс хойш 5 жилээс хэтрэхгүй хугацаанд хүчин төгөлдөр байна.

Хавсралт А5-II

Далайн хөдөлмөрийн гэрчилгээ

Далайн хөдөлмөрийн гэрчилгээний загвар маягтын төгсгөлд дараах бичвэрийг нэмэх:

Шинэчлэх шалгалт хийгдсэний дараах сунгалт (хэрэв шаардлагатай бол)

Шинэчлэх шалгалт хийгдсэний дараа хөлөг онгоц нь үндэсний хууль тогтоомж, эсхүл энэхүү Конвенцын шаардлагыг хэрэгжүүлэх бусад арга хэмжээний шаардлагад үргэлжлүүлэн нийцсэн хэмээн дүгнэсэн тул Стандарт А5.1.3-ын 4 дэх хэсгийн дагуу шинэ гэрчилгээг олгож, хөлгийн тавцан дээр бэлэн байлгахыг зөвшөөрч, одоо байгаа гэрчилгээг хүртэл (одоо байгаа гэрчилгээний хугацаа дуусахаас өмнө 5 сараас хэтрэхгүй) хугацаагаар сунгасан болохыг үүгээр гэрчлэв.

Сунгалт хийх үндэслэл болсон шинэчлэх шалгалт хийж дууссан огноо:

.....

Гарын үсэг:
(Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг)

Газар:

Огноо:

(Олгосон байгууллагын тамга, тэмдгийн аль тохирохыг дарах)

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БАГА ХУРАЛ

ДАЛАЙН ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ 2006 ОНЫ КОНВЕНЦОД
2018 ОНД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСНЫГ ТУС БАГА ХУРЛЫН 2018
ОНЫ 6 ДУГААР САРЫН 5-НЫ ӨДӨР ЖЕНЕВ ХОТНОО БОЛСОН 107
ДУГААР ЧУУЛГАНААР БАТЛАВ.

ДАЛАЙН ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ 2006 ОНЫ КОНВЕНЦЫН АКТАД 2018 ОНД ОРУУЛСАН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

**Далайн хөдөлмөрийн тухай 2006 оны конвенцын Журам 2.1-т
холбогдох Актад оруулсан нэмэлт, өөрчлөлт**

Стандарт А2.1 – Далайчны хөдөлмөрийн гэрээ

7 дахь хэсгийг шинээр нэмэх:

7. Гишүүн улс бүр далайчны хөдөлмөрийн гэрээг түүний хүчинтэй хугацаа дууссан, эсхүл аль нэг тал түдгэлзүүлэх, эсхүл цуцлах мэдэгдэл өгсөн эсэхээс үл хамааран хөлөг онгоцны эсрэг далайн дээрмийн үйлдэл, эсхүл зэвсэглэсэн дээрэм тонуулын үр дүнд далайчин нь хөлөг онгоцон дээр, эсхүл түүний гадна олзлогдсон үед хүчинтэй хэвээр байлгахыг шаардана. Энэ хэсгийн зорилгын хүрээнд дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

(a) “*далайн дээрэм*” гэж Нэгдсэн Үндэстний Байгууллагын 1982 оны Далайн эрх зүйн тухай конвенцод заасан утгаар ойлгоно;

(b) “*хөлөг онгоцны эсрэг зэвсэглэсэн дээрэм тонуул*” гэж улсын дотоодын ус, олтригийн ус болон харьяа тэнгист хувийн зорилгоор хөлөг онгоцны эсрэг чиглэсэн, эсхүл тухайн хөлөг онгоцон дээрх хүмүүс, эсхүл өмч, эд хөрөнгийн эсрэг үйлдсэн далайн дээрмийн үйлдлээс бусад хүчирхийллийн аливаа хууль бус үйлдэл, эсхүл хорих, эсхүл довтлон тонох аливаа үйлдэл, эсхүл заналхийлэх, эсхүл дээр дурдсан аливаа үйлдлийг өдөөн хатгах буюу санаатайгаар нөлөөлөхийг хэлнэ.

**Далайн хөдөлмөрийн тухай 2006 оны конвенцын Журам 2.2-т
холбогдох Актад оруулсан нэмэлт, өөрчлөлт**

Стандарт А2.2 – Хөдөлмөрийн хөлс

7 дахь хэсгийг шинээр нэмэх:

7. Хөлөг онгоцны эсрэг далайн дээрмийн үйлдэл, эсхүл зэвсэглэсэн дээрэм тонуулын үр дүнд далайчин нь хөлөг онгоцон дээр, эсхүл түүний гадна олзлогдсон үед далайчны хөдөлмөрийн гэрээ, холбогдох хамтын гэрээ, эсхүл дотоодын хууль тогтоомжийн дагуу энэхүү Стандартын 4 дэх хэсэгт заасан аливаа мөнгийг гуйвуулах зэрэг түүний цалин хөлс болон бусад эрхийг олзлогдсон бүх хугацаанд, түүнчлэн суллагдаж Стандарт А2.5.1-ийн дагуу эх орондоо буцах хүртэлх хугацаанд, эсхүл далайчин нь олзлогдсон үедээ нас барсан бол холбогдох дотоодын хууль тогтоомж, журмын дагуу нас барсан өдрийг тодорхойлох хүртэлх хугацаанд үргэлжлүүлэн төлнө. “Далайн дээрэм” болон “хөлөг онгоцны эсрэг зэвсэглэсэн дээрэм тонуул” гэсэн нэр томъёог Стандарт А2.1-ийн 7 дахь хэсэгт заасан утгаар ойлгоно.

Далайн хөдөлмөрийн тухай 2006 оны конвенцын Журам 2.5-т холбогдох Актэд оруулсан нэмэлт, өөрчлөлт

Удирдамж В2.5.1 – Эрх олгох

8 дахь хэсгийг дараах байдлаар өөрчлөх:

8. Хэрэв дотоодын хууль тогтоомж, эсхүл хамтын хэлэлцээрээр тодорхойлсон зохих хугацааны дотор хөлөг онгоцны эсрэг далайн дээрмийн үйлдэл, эсхүл зэвсэглэсэн дээрэм тонуулын үр дүнд хөлөг онгоцон дээр, эсхүл түүний гадна олзлогдсоноос бусад тохиолдолд далайчин эх орондоо буцах тухай мэдэгдээгүй бол эх орондоо буцах эрх цуцлагдах боломжтой. “Далайн дээрэм” болон “хөлөг онгоцны эсрэг зэвсэглэсэн дээрэм тонуул” гэсэн нэр томъёонууд нь Стандарт А2.1-ийн 7 дахь хэсэгт заасан утгатай адил байна.

Дээр дурдсан нэмэлт, өөрчлөлтийн эх бичвэрийг Женев хотноо болж, 2018 оны 06 дугаар сарын 08-ны өдөр хаагдсан гэж зарлан тунхаглагдсан Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Ерөнхий бага хурлын 107 дугаар чуулганаар албан ёсоор баталсан болно.

ҮҮНИЙГ ГЭРЧЛЭН бид 2018 оны 06 дугаар сарын энэ өдөр гарын үсэг зурж баталгаажуулав.

Ерөнхий бага хурлын Ерөнхийлөгч

Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Ерөнхий захирал

---o0o---



Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 1.25

Индекс: 200003